

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны  
12 дугаар сарын 27-ны өдрийн 11:00  
дугаар тушаалтын хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### Албан тушаалтын тодорхойлолт боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
 шинэчлэн боловсруулсан  
 Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалтын тодорхойлолтыг баталсан огноо:

2023.12.27

11:00

#### Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

#### Нэгжийн нэр:

Мөрдөн байцаах алба

#### Албан тушаалтын нэр:

Албаны дарга

#### Албан тушаалтын ангилал, зэрэглэл:

ТТ-1

#### Ажлын цаг:

8 цаг

#### Ажлын байрны албан ёсны байршил:

Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Самбуугийн гудамж-18

#### Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

#### Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гол түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон бусад аюул тохиолдсон, нийтийн эмх замбараагүй байдал үссэн, террорист халдлага, онц болон дайны байдал зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн зэрэг зайлшгүй тохиолдолд уртгасгасан цагаар болон өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

#### Албан тушаалтын зорилго:

Цагдаагийн албаны тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, Мөрдөн байцаах албаны бодлогыг тодорхойлж, мөрдөн шалгах ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга нарын өмнө гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах ажлыг хариуцах, байгууллага, алба хаагч, бусад ажиллагсдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах.

#### Албан тушаалтын зорилт:

1. Гэмт хэрэгтэй тэмцэх ажил, мөрдөн шалгах ил болон нууц ажиллагаатай холбоотой асуудлаар Цагдаагийн төв байгууллагын дарга, тэргүүн дэд дарга нарыг мэдээллээр хангах, санал тавих.

- 2.Мөрдөн байцаах албаны ажлын чиг үүргийг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах.
- 3.Алба хаагчдын үйл ажиллагааг Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн актад нийцүүлж, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах.
- 4.Мөрдөн байцаах албаны төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх.
- 5.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах –Т, Харилцан, гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1.Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомж, холбогдох бусад эрх зүйн актын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, санал боловсруулж танилцуулах;</p> <p>1.2.Гэмт хэрэгтэй тэмцэх ажилтай холбогдсон асуудлаар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга нарыг мэдээллээр хангах;</p> <p>1.3.Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах тооцоо, судалгаа, мэдээ, материалыг хуульд харшлаагүй бол холбогдох байгууллага, аж ахуйн нэгжээс гаргуулан авах;</p> <p>1.4.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцыг хэрэгжүүлэх, тэдгээрт нийцүүлж хууль тогтоомж боловсруулахад саналаа танилцуулах;</p> <p>1.5.Төсвийн ерөнхийлөн захирагч Цагдаагийн төв байгууллагын даргатай итгэлцлийн гэрээ байгуулах, биелэлтийг хангах.</p>	Удирдлага шаардлагатай мэдээллээр хангагдсан байна.	Г  Г, Х, Ш  Г  Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1.Хариуцсан алба, нэгжийн үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарах ажлыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журамд заасны дагуу холбогдох заалтыг баримтлан удирдан зохион байгуулж, хэрэгжүүлэх;</p> <p>2.2.Цагдаагийн ерөнхий газар, Мөрдөн байцаах албанаас дэвшүүлсэн зорилт, хүрэх түвшин, түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан ажлын биелэлтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах, танилцуулах;</p> <p>2.3.Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн байгууллагын төлөвлөгөөг боловсруулан, батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг удирдан зохион байгуулах;</p>	Гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах болон гүйцэтгэх ажлын үр дүн дээшилсэн байна.	Г, Х  Г, Х  Г, Х, Ш

	<p>2.4.Албаны үйл ажиллагааг өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангаж, Цагдаагийн ерөнхий газрын удирдлагыг тогтмол мэдээллээр хангах;</p> <p>2.5.Харьяаллын хэргийн мөрдөн шалгах болон мөрдөн шалгах нууц ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасныг удирдлага болгон зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах;</p> <p>2.6.Цагдаагийн албаны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 10 дугаар зүйлд заасан ажлыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих;</p> <p>2.7.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3-т заасан үйл ажиллагааны хэрэгжилтэд холбогдох заавар, журмыг баримтлан хяналт тавьж ажиллах;</p> <p>2.8.Шинэчлэгдэн батлагдсан хуулиудтай уялдуулан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код/-ыг мөрдөх шинэчилсэн, хүчингүй болгосон нэмэлт өөрчлөлт оруулсан тохиолдол бүрт хэрэгжүүлж ажиллах.</p>		Г Г, Х Г, Х Г, Х Г, Х
3 дугаар зорилтын хурээнд	<p>3.1.Эрх хэмжээнийхээ хүрээнд албаны хэмжээнд дагаж мөрдүүлэх заавар, дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлэх;</p> <p>3.2.Хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилох, чөлөөлөх, албан тушаалаас бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл оногдуулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх, халах саналыг Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлж шийдвэрлүүлэх;</p> <p>3.3.Албаны хэмжээнд хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</p> <p>3.4.Хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх арга хэмжээ авах санал хүргүүлж шийдвэрлүүлэх;</p> <p>3.5.Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p> <p>3.6.Алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үр дүнг тооцох;</p>	<p>Байгууллагын үйлчилгээ иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүрч алба хаагчдын ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудал сайжирсан байна.</p>	<p>Г, Х Х, Ш Х, Ш Г, Х, Ш Г, Х, Ш</p>

	3.7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1.6-д заасныг хэрэгжүүлэх.		X, Ш
4 дүгээр зорилтын хурээнд	4.1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 801-804, 810-815-д заасан ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх; 4.2. Төсвийн байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох заавар, журмыг сахин биелүүлж, санхүүгийн дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоог бурдүүлэх; 4.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-д заасан зардлын төсвийг шийдвэрлүүлж зарцуулалтад хяналт тавих.	Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх зарчим хэрэгжсэн байна.	X, Ш
Хууль тогтоомж, дүрэм журмаар хүлээлгэсэн албан тушаалын зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх	6.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид, иргэдтэй зөв боловсон харьцах, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй байх; 6.2. Авлига, хүнд суртлаас ангид байж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн шударга ёсыг эрхэмлэн, "Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг чанд мөрдөх; 6.3. Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.	-	Г Г Г

### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд боловсролтой, магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	-Эрх зүй /0421/ -Менежмент ба удирдахуй /0413/ -Иргэн, өмч хөрөнгө хамгаалал /1032/ -Аюулгүй байдлыг хангах /103901, 103912/		
Мэргэшил	Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх.		
Туршлага	Цагдаагийн байгууллагад 15-аас доошгүй жил ажилласан, үүнээс хэлтсийн дарга, түүнтэй адилтгах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан, удирдах болон мэргэжлийн ажлын дадлага туршлагатай, улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй байх.		
Үр чадвар	Удирдан зохион байгуулах	-Байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх; -Байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх.	
	Дүн шинжилгээ хийх	-Мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, системийн шинжилгээ хийх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, харьцуулсан судалгаа хийх; -Бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах.	
	Асуудал шийдвэрлэх	-Хуульд нийцсэн шийдвэр гаргах; -Оновчтой, шуурхай, үр дүнтэй шийдвэр гаргах; -Аливаа харилцааг хэрэгжүүлэх арга замыг хууль, тогтоомж шийдвэрийн төсөлд тусгах;	

		<ul style="list-style-type: none"> <li>-Албан тушаалын бүрэн эрхийн хүрээг баримталж шийдвэр гаргах;</li> <li>-Гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх.</li> </ul>
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>-Ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дуурайл үзүүлэх;</li> <li>-Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах;</li> <li>-Байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг бусдад итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх.</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>-Албан хэрэг хөтлөлт боловсруулах, монгол хэл, бичгийн дүрэм, уг зүй, найруулга зүйн зохих мэдлэгтэй байх.</li> <li>-Компьютерийн Microsoft Office Word, Microsoft Office Excel, Microsoft Office Power Point программуудыг хэрэглээний түвшинд ашиглах чадвартай байх.</li> <li>-Нууц хадгалах.</li> </ul>

#### IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Цагдаагийн ерөнхий газрын дарга

Албан тушаалд шууд харьялан  
удирдуулах албан тушаалын нэр, тоо:  
Батлагдсан орон тоо.

Бусад харилцах субъект:

Шууд харилцах байгууллага:

-Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан;  
Шууд бус харилцах байгууллага:  
-Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэн; /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

#### V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ:

Албан тушаалын тодорхойлолтыг  
боловсруулсан:

Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА  
  
Т.ГАНЗОРИГ  
  
2023 оны 12 дугаар сарын 27.-ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг  
хянаж, батлах зөвшөөрөл олгосон  
байгууллагын шийдвэр:

Байгууллагын нэр: .....  
Шийдвэрийн огноо: .....  
Дугаар: .....


Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗР  
Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27.-ны өдөр  
Дугаар: 27. ....

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.СҮХБОЛД

2023 оны 27 дугаар сарын 27.-ны өдөр



**ТАНИЛЦСАН:**

Албан тушаалтан: .....

20...оны .... дугаар сарын ....-ны өдөр